

КОВИД-19 БА МОНГОЛ ДАХЬ ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДАЛ





КОВИД-19 БА МОНГОЛ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Энэхүү судалгааг Фридрих-Эбертийн сангийн захиалгаар хийж гүйцэтгэв.

Судалгааны аливаа агуулга, мэдээллийн үнэн зөвийг судлаач хариуцах бөгөөд Фридрих-Эбертийн сангийн байр суурьд нийцэж байх албагүй болно.

Судлаач: Др. С.Даваасүрэн

©ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас эрхлэн гаргав. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэх нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

**КОВИД-19 БА МОНГОЛ ДАХЬ ЖЕНДЕРИЙН
ТЭГШ БАЙДАЛ**

АГУУЛГА

Судалгааны үндэслэл	5
Монгол дахь жендэрийн тэгш байдал	6
Тоон болон чанарын судалгааны үр дүн	9
I. Эмэгтэйчүүд ба ажил эрхлэлт	9
II. Гэр бүлийн хүчирхийлэл ба эмэгтэйчүүд	13
III. Эхийн эндэгдэл	15
IV. Сэтгэцийн эрүүл мэнд	16
Дүгнэлт, бодлогын зөвлөмж	16
Ашигласан материал	19
COVID-19 AND THE PERSPECTIVES FOR GENDER JUSTICE IN MONGOLIA	21

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн улс орнуудад **хүйс, арьс өнгө, нийгмийн анги давхарга, баялгийн ялгаатай байдал, кастын систем** зэргээс иргэдийн дунд **тэгш бус байдал** бий болдог. Тэгш бус байдлыг бууруулахын төлөө дэлхийн улс орнууд хичээл зүтгэл гаргасаар байгаа ч дотоод болон гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр тэгш бус байдал буурахгүй, зарим тохиолдолд өсөх хандлага ажиглагдаж байна.

Ковид-19 цар тахлын улмаас дэлхий даяар нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд боловсрол, хөдөлмөр эрхлэлт зэрэг олон салбарт хүндрэлтэй нөхцөл байдал бий болсон бөгөөд Монгол Улс ч гэсэн уг хүндрэлтэй нүүр тулсан. Монгол Улсад 2020 оны 1 дүгээр сарын сүүлээс хэсэгчилсэн хөл хорио тогтоож, 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс дотоодын халдварын анхны тохиолдол бүртгэгдсэнээр хатуу хөл хорионы дэглэмийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр **“Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай”** хуулийг баталж, бүх нийтээр дагаж мөрдөв. Ингэхдээ олон хүний бөөгнөрөл үүсгэхгүй байх, хил хаах, аймаг хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хориглох, зарим худалдаа, үйлчилгээ, олон нийтийн болон бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг зогсоох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Ковид-19 цар тахлын хямралыг даван туулах арга хэмжээ нь нийт иргэдийн сайн сайхан байдлыг хангах хэрэгцээнд тулгуурласан ч цар тахлын нөхцөл байдлаас шууд хамааралтайгаар эдийн засаг, нийгмийн амьдралд мэдэгдэхүйц сөрөг үр дагаврууд бий болсон. Тэр дундаа Монгол улсын Тогтвортой хөгжлийн зорилгын **“Жендерийн эрх тэгш байдлыг хангах”** 5 дугаар зорилгод тодорхойлсон төрийн аливаа үйлчилгээг хүргэхдээ хүний эрхийг хангахын тулд жендерийн мэдрэмжтэй бодлогуудыг илүүтэй авч хэрэгжүүлэх, жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хямралаас иргэдээ хамгаалах нийгмийн хамгааллын арга хэмжээг тогтмол үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын үр дүн хангалтгүй байна.

Монгол Улс жендерийн тэгш бус байдлын үзүүлэлтээр **2019 онд дэлхийн 189 орноос 71-д эрэмбэлэгдсэн** нь жендерийн тэгш бус байдлыг бууруулах, тэр дундаа эмэгтэйчүүдийн улс төрийн болон эдийн засгийн тэгш байдлыг хангах чиглэлээр дорвитой ажиллах шаардлагатайг харуулж байгаа юм.

Ковид-19 цар тахал нь жендерт суурилсан тэгш байдалд хэрхэн нөлөөлсөн, жендерийн тэгш байдлыг хангахын тулд цаашид юу хийх шаардлагатай, өнгөрсөн хугацааны үйл явдлаас авсан сургамж, ирээдүйд хийж хэрэгжүүлэх шаардлагатай бодлого, арга замын талаар санал дүгнэлт, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажил чиглэгдэх юм.

МОНГОЛ ДАХЬ ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ

Монгол улс эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрх, шударга ёсыг **1924 оны үндсэн хуульдаа** тунхагласан Ази тивийн анхны улс бөгөөд 1961 онд НҮБ-д элссэнээс хойш жендерийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн эрхтэй холбоотой олон улсын конвенц, гэрээ хэлэлцээрт нэгдэн орж, соёрхон баталсан¹.

1996 онд **“Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах үндэсний хөтөлбөр”**-ийг санаачилж, 2000 онд Жендерийн тэгш байдлын асуудал хариуцах Үндэсний зөвлөлийг байгуулж, тус зөвлөл нь 2005 он хүртэл **“Жендерийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”**-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байв. 2005 оноос Жендерийн тэгш байдлын Үндэсний Хороо байгуулагдаж үйл ажиллагаа нь өргөжсөн.

Монгол Улсын Засгийн газар Жендерийн тэгш байдлыг хангах, хүний эрх, ялангуяа эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалахын төлөө **Жендерийн тэгш байдлыг хангах хөтөлбөрийг** 2003-2015 онд хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд **“Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2004)”**, **“Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)”**, **“Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль (2011)”**, **“Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)”** зэрэг хэд хэдэн хуулийг УИХ-аар батлуулж, жендерийн эрх тэгш байдлыг хангах эрх зүй, бодлогын орчин бүрдүүлсэн.²

Улс орнуудын жендерийн үнэлгээний тайланд “Монгол улс нь жендерийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн тогтолцоо сайтай” хэмээн дурдагдсан байдаг³. Гэвч Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь Монголын эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж байна гэсэн дүгнэлтийг ч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн (НҮБХХ) хүрээнд Азийн Хөгжлийн Банк (АХБ) болон Жендерийн үндэсний хороо

1 “Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага”, MERIT., 2020

2 “Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн Газар., 2017-2021

3 “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага”, MERIT., 2020

(ЖҮХ)-ны хамтарсан судалгааны тайланд⁴ дурдсан байна.

Монгол Улсад жендерийн тэгш байдлыг хангаж, хүйсээр ялгаварлан гадуурхахгүй байх суурь зохицуулалтыг тусгасан **10 гаруй хууль, 5 бодлогын баримт бичиг** байдаг ч тэдгээр хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь жендерт суурилсан тэгш бус байдал өндөр байгаагаар нотлогддог.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд зааснаар **«эрэгтэй, эмэгтэй хүмүүс нь гэр бүлийн дотор ба соёл, нийгэм, эдийн засгийн болон улс төрийн хувьд ижил тэгш эрхтэй байна»** гэж заасан.

Төрийн, улс төрийн албан тушаалтнуудын жендерийн байдлыг авч үзвэл Монгол Улсын Их Хурлын гишүүдийн **17.1 хувь**, Засгийн газрын гишүүдийн **13.6 хувь**, Дэд сайд нарын **6.2 хувь**, Аймгийн засаг дарга нарын **4.8 хувь**, Дүүргийн засаг дарга нарын **11.1 хувь** эмэгтэйчүүд байгаа нь дэлхийн парламентын засаглалтай ардчилсан улс орнуудтай харьцуулахад маш доогуур үзүүлэлт юм.

Дэлхийн дунджаар их, дээд сургууль төгсөөд 10 жил болсон, ахисан түвшний боловсролтой эмэгтэй ижил түвшний боловсролтой эрэгтэйтэй харьцуулахад 23 хувиар бага цалин хөлс авдаг. Монгол Улсад эмэгтэйчүүдийн дээд болон ахисан түвшний боловсрол эзэмшсэн байдал эрэгтэйчүүдтэй харьцуулахад нэлээд өндөр байдаг ч, цалин нь 17 хувь доогуур байна.

Статистикийн тоон мэдээллээр, манай улсын эрүүл мэндийн салбарын 80 гаруй, боловсролын салбарын 70 гаруй, банк санхүү, даатгалын салбарын 70 орчим, жижиглэн худалдаа, засвар үйлчилгээний салбарын 60 орчим, хөнгөн үйлдвэрлэлийн 50 гаруй хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

Тухайлбал, Ковид-19 цар тахлын онцгой нөхцөл бүхий гурван жилийн хугацаанд иргэдийн эрүүл мэндийн манаанд ажиллах амаргүй бөгөөд хүнд ачааг эмэгтэйчүүд үүрсэн байна.

4 “Монгол улсад Ковид-19 цар тахлын охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа” НҮБХХ, АХБ, ЖҮХ., 2020

Хүснэгт 1. Эрүүл мэндийн салбарт ажиллагсад, 2019-2021 он /хүйсээр/

	2019	2020	2021	дундаж
Бүгд	54687	56502	58696	56628.3
Үүнээс: эмэгтэй	44807 (81.93%)	46379 (82.08%)	48163 (82.05%)	46449.7 (82.02%)

Эх сурвалж: ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт

Хүснэгт 1-д үзүүлснээр Монгол Улсын эрүүл мэндийн салбарт ажиллагсдын **82 хувь** нь эмэгтэй ажиллагсад⁵ байгаа нь олон улсын түвшинтэй харьцуулахад өндөр үзүүлэлт юм. Цар тахлын үед эрүүл мэндийн салбарын ажлын ачаалал хэд дахин нэмэгдсэний дээр халдвараар өвчлөх эрсдэл ч төдий хэмжээгээр өссөн тоон мэдээлэл байна.

Харин, өмч, хөрөнгө эзэмшиж байгаа байдлыг авч үзвэл, орон сууц өмчлөлөөр Монголын эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс **2 дахин бага**, газар эзэмшлийн хувьд **3-6 дахин бага**, бусад үл хөдлөх хөрөнгө эзэмшлийн хувьд **1.5 дахин бага** байна.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ) мэдээлснээр 2021 оны эцсийн байдлаар манай улсад **147 мянга** гаруй аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 92.5 мянга буюу 63 орчим хувь нь эрэгтэй, 54 мянга гаруй буюу **37 хувь нь эмэгтэй** удирдлагатай байна.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан (ЖДҮХС)-аас олгосон нийт зээлийн үлдэгдэл 2021 оны эцсийн байдлаар 5.6 их наяд төгрөгт байгаагаас, тус санд зээлийн үлдэгдэлтэй компаниудын 64 хувь нь эрэгтэй, **36 хувь нь эмэгтэй** удирдлагатай байна. Жижиг болон бичил бизнес эрхлэгчдийн олонх нь эмэгтэйчүүд байдаг бол ЖДҮХС-аас зээл авсан аж ахуйн нэгжийн ердөө **гуравны нэг** нь эмэгтэй удирдлагатай аж ахуйн нэгжүүд байна.

АНУ, Энэтхэг зэрэг улсуудад Ковид-19 цар тахлын үеийн эмэгтэйчүүдийн ажлын байр алдалт 5.7% байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 1.8 дахин эмзэг байна. Эмэгтэйчүүд дэлхийн хэмжээнд ажил эрхлэлтийн **39 хувийг** бүрдүүлдэг боловч ажлаа алдаж байгаа хүмүүсийн **54 хувийг** эзэлж байна. Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт дунджаас өндөр хурдаар буурч байгаа нь эмэгтэй ажиллагсад

5 ЭМХТ. Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт. 2021

давамгайлсан салбарууд цар тахалд илүү өртсөний нотолгоо юм⁶.

ҮСХ-ны мэдээллээр 2022 оны эхний хагас жилд Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчний оролцооны түвшин, эмэгтэйчүүдийнх **52 хувь**, харин эрэгтэйчүүдийнх **68 хувь** байна. Улсын хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар **60 гаруй хувьтай** байгаа нь 100 хүн тутмын ердөө 60 нь ажиллах сонирхолтой байгаа бол эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн ажиллах сонирхол даруй **17 орчим пунктээр** доогуур байгаа нь анхаарал татсан асуудал болоод байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мэдээлснээр цалин хөлсгүй ажил эрхэлдэг эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 3 дахин их байдаг. Манай улсад дээд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн тоо өндөр ч хөдөлмөрийн зах зээлд тэдний оролцоо бага байна, ялангуяа 25-аас 34 насны эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин харьцангуй буурсан дүнтэй байна.

Эрэгтэй, эмэгтэй ажиллагсдыг цалингийн хувьд харьцуулж үзвэл эрэгтэй ажиллагсдын сарын дундаж цалин **1.6 сая төгрөг байхад эмэгтэйчүүдийнх 1.3 сая төгрөг буюу 300 мянган төгрөгөөр бага байна (ҮСХ).**

Ковид-19 цар тахал нь эрүүл мэнд, нийгэм, эдийн засаг болон хүмүүнлэгийн хямралыг улам бүр нэмэгдүүлсэн. Энэ байдал нь жендерийн тэгш бус байдлыг гүнзгийрүүлж болзошгүй нөхцөл байдал үүссэнийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн бухимдлын чиглэлээр болон хөдөлмөрийн зах зээл дээр хийсэн тоон болон чанарын судалгааны үр дүн харуулж байна.

ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

I. Эмэгтэйчүүд ба ажил эрхлэлт

Ковид-19 цар тахал нь эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд илүүтэйгээр сөрөг нөлөө үзүүлсэн байна.

Цар тахлын улмаас бизнес эрхлэгчид ихээхэн хүнд байдалд орсон. Урт хугацааны хөл хорио нь бизнесийн үйл ажиллагааг жигд бус болгож, олон газрууд

6 Madgavkar, A., White, O., Krishnan, M., Mahajan, D., & Azcue, X. (2020, July 15). Covid-19 and gender equality: Countering the regressive effects. McKinsey & Company. from <https://www.mckinsey.com/featured-insights/future-of-work/covid-19-and-gender-equality-countering-the-regressive-effects>

цомхотгол хийх, хаалгаа барих, бизнесээ зогсоох хүртэл арга хэмжээ авсан бол зарим салбар, тэр дундаа эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсдын ачаалал эрс нэмэгдсэн томоохон өөрчлөлтүүд гарсан байна.

Манай улсын боловсролын салбарт ажиллагсдын 70 гаруй хувь нь эмэгтэйчүүд бөгөөд цар тахлын үед танхимын сургалтаас зайн сургалтад шилжсэнээр багш нарын ачаалал, зардал нь нэмэгдсэн байна. Зайн сургалтын хэлбэр нь анхан, дунд, их дээд гээд бүх шатны боловсролын системд нэвтэрч эхэлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хувьд, тухайн хичээлийг бэлтгэхэд зарцуулах цаг, багшаас гарах зардал өссөн байна. Тухайлбал, багш нарт ухаалаг гар утастай болох, өндөр хурдны интернэттэй байх, шаардлагатай тохиолдолд зөөврийн компьютертой болохтой холбоотойгоор тэднээс гарах зардлууд өсжээ.

Судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын теле хичээл болон цахим хичээл эхэлснээс хойш эмэгтэй багш нарын 79 хувь, харин эрэгтэй багш нарын 60 хувь нь ажлын ачаалал, хичээл заахтай холбоотой зардал өссөнийг хүлээн зөвшөөрсөн байна.⁷

“Монгол Улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа”-нд хамрагдсан бага, дунд сургуульд олон жил багшилсан, танхимын сургалтад дадсан эмэгтэй багш нар урьд нь цахим хичээл зааж байгаагүй, энэ чиглэлээр сургалт авч байгаагүй учраас шинэ арга барилдаа дасахад хүндрэлтэй байснаас олон цагаар ажилласан, сэтгэл санааны дарамтад орсон, цаашлаад тэднээс гарах зардал өссөн зэрэг хүндрэлийг дурдсан байна. Танхимын сургалтын үед сургууль дээр ажилласан цагт илүү цагийн хөлс олгодог, анги удирдсан багшийн нэмэгдэл зэрэг багшлах ажилд олгодог нэмэлтүүд зогссоноос бодит цалингийн орлого цар тахлын үед буурсан байна.

Азийн сангийн **“Монголын жижиг болон бичил бизнес⁸ эрхлэгч эмэгтэйчүүдэд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ”**

7 2020 оны 11 сард цахимаар явуулсан “Монгол Улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа”-ны үр дүн, НҮБХХ, АХБ, ЖҮХ.

8 ЖДҮҮ-г дэмжих тухай хуульд зааснаар жилийн орлого нь 300 саяас 1 тэрбум хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10-50 хүнийг ажлын байраар хангадаг бизнесийг “жижиг бизнес”, харин 300 сая хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10 хүртэлх хүнтэй бизнесийг “бичил бизнес” гэнэ.

сэдэвт түүвэр судалгааны үр дүнгээс⁹ цар тахлын үед эмэгтэй удирдлагатай ихэнх бизнесийн нийлүүлэлтийн сүлжээ тасарч, худалдаа, үйлдвэрлэлийн хэмжээ эрс буурч, зарим тохиолдолд түр болон бүрмөсөн бизнесээ зогсоож, ажиллагсдаа халсан байна. Цар тахлын хөл хорионы үеийн бизнесийн үйл ажиллагааны доголдлыг дагаад эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүгийн байдал нь улам хүндэрсэн байна. Бизнес эрхлэгч эмэгтэйчүүд цар тахлын өмнө ч санхүүгийн эх үүсвэр дутагдалтай, санхүүжилт тааруу байсан гэдгийг энд дурдах нь зүйтэй.

Манай улсын хувьд өрхийн бизнес, лангуу, зах дээр үйл ажиллагаа эрхлэх зэрэг жижиг дунд бизнесийн 80-90 хувь нь эмэгтэйчүүд бөгөөд 2021 оны 6 дугаар сард хийсэн судалгаагаар цар тахлын үед эмэгтэйчүүд ажлаа алдах, зогсоох магадлал эрэгтэйчүүдээс илүү өндөр болсон байна. Цар тахлаас өмнө ажил эрхэлж байсан **эмэгтэйчүүдийн 42 хувь**, харин **эрэгтэйчүүдийн 27 хувь** нь ажил эрхлэхээ больсон бол ажил эрхлэхээ больсон эмэгтэйчүүдийн 70-аас илүү хувь нь буцаж орох ажил байхгүй гэж хариулсан нь тэднийг бүрмөсөн ажлаа алдах эрсдэлтэй болсныг харуулж байна.


Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин манай улсад 2006 оноос хойш буурч байгаа бөгөөд цар тахлын үед хамгийн доод түвшин буюу 50 хувиас бага болсон¹⁰.

Хөл хорионы эхэн үед ихэнх ажил олгогчид эмэгтэй ажиллагсдаа эрэгтэйчүүдээс илүү уян хатан нөхцөлийг санал болгож, 4 эмэгтэй тутмын нэг нь гэрээсээ болон богиносгосон цагаар ажиллах боломжийг олгосон байна. Тус арга хэмжээ нь эмэгтэйчүүдэд үр хүүхдээ асрах давуу талыг олгосон боловч нөгөө талдаа хүүхэд асрах ажлыг зөвхөн эмэгтэйчүүдийн нуруун дээр үүрүүлснээр жендэрийн тухай хэвшмэл ойлголт, жендэрийн тэгш бус байдал нийгэмд гүнзгийрэхэд нөлөөлөх хүчин зүйл болсон байна (НҮБХАС, 2020).

9 Азийн сангийн Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төсөл болон Хараат бус Судалгааны хүрээлэн (IRIM) нь Канадын Гадаад Хэргийн Яамны дэмжлэгтэйгээр тус судалгааг 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 7 дугаар сарын хооронд явуулсан байна.

10 2021 оны урьдчилсан тоон мэдээллээр эмэгтэй ажиллах хүчний оролцооны түвшин 49.9 хувь болж буурсан (ҮСХ). https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NSO_0400_018V1

График 1. Ажилгүйчүүд, ажилгүйдлийн түвшин /хүйсээр/



Эх сурвалж: УСХ

2020 оны 3-аас 4 дүгээр улирал, 2021 оны 1-ээс 2 дугаар улиралд хатуу хөл хорио тогтоож, бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнээр эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин огцом нэмэгдсэн байна. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 2020 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 1.3 хувь, ажилгүй эмэгтэй хүний тоо **16 хувиар** тус тус өссөн байна. 2021 оны 2 дугаар улиралд эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин цар тахал гарснаас хойших оргил үе буюу **8.6 хувьд** хүрсэн нь тэдний ажлын байрны эмзэг байдлыг харуулж байна.

Цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэл үргэлжилсээр байгаа нь бага насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд уян хатан ажиллах нөхцөлийг санал болгох, ажил олгогчдын тоо цөөрөхөд хүрсэн. Учир нь ажил олгогчид хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл, зайнаас ажиллах зэрэг зохицуулалт нь эдийн засгийн хүндрэлтэй үед бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх зохистой шийдэл биш гэж үзэх болсон.

Цар тахлын өмнө 2019 онд Монгол эмэгтэйчүүд 7 хоногт дунджаар **4.5 цагийг** хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг байсан. Энэ нь эрэгтэйчүүдээс **2 дахин өндөр** байсан бол цар тахлын үед эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй хөдөлмөрт зарцуулдаг цаг, хийж гүйцэтгэх ажил үүрэг улам нэмэгдсэн болохыг Үндэсний статистикийн хорооноос хийсэн судалгааны үр дүн харуулж байна.

Азийн сан болон Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим (МУХАУТ)-аас хийсэн судалгаагаар цар тахлын үед эмэгтэйчүүдийн бизнесийн

үйл ажиллагаа тасалдаж, дампуурсан нь тэднийг санхүүгийн болон сэтгэл зүйн дарамтад оруулсан сөрөг нөлөөтэй байна.

Цар тахалтай холбоотой хөл хорио, түүний эдийн засгийн сөрөг үр дагаврын улмаас богино болон дунд хугацаанд хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийн оролцоо буурч, тэдний бизнесийн орлого муудаж, аж ахуйн үйл ажиллагаагаа зогсоож, дампуурсан нь гэр бүлийн харилцаанд нь сөргөөр нөлөөлж, гэр бүлийн маргаан, хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн тоо цар тахлын үед өссөн байна. Цаашлаад охид, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж цар тахлын үед буурсан, эхийн эндэгдэл өссөн зэрэг нь жендэрийн тэгш байдалд сөргөөр нөлөөлжээ.

II. Гэр бүлийн хүчирхийлэл ба эмэгтэйчүүд

Эдийн засгийн хямрал, нийгмийн стресс, хөл хорионоос шалтгаалан хүйсийн тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийлэл дэлхийн олон оронд нэмэгдсэн тоо баримт байна. Цар тахалтай холбоотойгоор **3 эмэгтэй тутмын нэг нь хүчирхийлэлд өртсөн**, тэдний эрх зөрчигдсөнтэй холбоотой зардал 1.5 их наяд ам.долларт хүрсэн тооцоолол ч байна.

Манай улсын хувьд өнгөрсөн гурван жилийн хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн талаарх мэдээлэл, тусламж үйлчилгээний хэрэгцээ эрс нэмэгдсэн¹¹ бөгөөд НҮБХАС-гийн судалгаанд¹² дурдсанаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчил **47 хувь өссөн** байна. Хөл хорио эмэгтэйчүүдийг илүү удаан хугацаанд хүчирхийлэгчийн хяналтад байлгах, тусламж авах боломжийг нь хязгаарлаж байгааг дээрх судалгаанд дурджээ.

11 Гэр бүлийн хүчирхийлэл: Статистик тойм, ЦЕГ, ҮСХ., 2020

12 “Ковид-19: Нөхцөл байдлын тайлан”, НҮБХАС., 2020 оны 6 сар No1.

График 2. Бүртгэгдсэн гэмт хэрэг /хүйсээр/



Эх сурвалж: УСХ

2022 оны 7 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн тоо 2976 бүртгэгдэж, өмнөх оны мөн үеийнхээс **63.9 хувиар** нэмэгдсэн байна. Эмэгтэй хүн оролцсон гэмт хэргийн тохиолдол 2022 онд өмнөх гурван жилийн дунджаас **1.6 дахин өссөн** байна. Энэ нь цар тахлын дараах эдийн засгийн хямрал, амьдралын чанар, нийгмийн хүрээнд эмэгтэйчүүдэд тулгарч буй олон хүндрэлээс үүдэлтэй байна.


“Монгол улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөлөл 2020” чанарын судалгаа, ярилцлагын үр дүнгээс гэр бүлийн хүчирхийллийн, ялангуяа хамтран амьдрагч, эрэгтэй гэр бүлийн гишүүний зүгээс хүүхэд, эмэгтэйчүүдэд хүчирхийлэл үйлдэх тохиолдлууд нэмэгдсэн байна.

Тухайлбал, Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам, НҮБХАС-тай хамтарсан **“Ковид-19 цар тахлын улмаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний түргэвчилсэн үнэлгээний тайлан”**-д дурдсанаар барилгын салбарт ажилладаг олонх эрчүүд цар тахлын үед хил хаагдаж, Хятад улсаас импортоор авдаг зарим материал саатсанаас барилгын бизнес нь зогсож улмаар ажилгүй гэртээ сууж, орлогогүй болсон нь гэр бүл дэх бухимдал стрессийг нэмэгдүүлэх томоохон хүчин зүйл болсон байна.

III. Эхийн эндэгдэл

Монгол Улс 2000-2015 онд Мянганы хөгжлийн зорилт (МХЗ)-ыг хэрэгжүүлэх хугацаандаа эхийн эндэгдлийн түвшнийг амжилттай бууруулж чадсан 9 орны нэг болж байсан.¹³ Гэвч 2021 оны жилийн эцсийн үзүүлэлтээр эхийн эндэгдэл нийт **68 тохиолдол**¹⁴ бүртгэгдсэн нь сүүлийн **10 жилд бүртгэгдээгүй** өндөр үзүүлэлт юм.

График 3. Эхийн эндэгдэл, 2011-2021 он



Эх сурвалж: ҮСХ

НҮБХАС-гийн 2020 оны 11-р сарын “Ковид-19 цар тахлын нөхцөл байдал”-ын тайланд дурдсанаар эхийн эндэгдэл нэмэгдэхэд коронавирусын халдвараас болгоомжилж, эмнэлэгт хандахаас зайлсхийх, эмэгтэйчүүдийн ар гэрийн ажлын ачаалал, үл хайхрал болон гэр бүлийн хүчирхийлэл зэрэг хүчин зүйлс нөлөөлсөн байх магадлалтай юм.

Зөвхөн Монгол Улсад төдийгүй, дэлхий даяар хүүхэд эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ авах явдал цар тахлын үед **20 хувиар** буурчээ¹⁵. Хөл хорио нь иргэдийн, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд зэрэг нийгмийн эмзэг бүлгийн тогтмол авдаг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд саад тотгор учруулсан болохыг судалгаа нотолж байна¹⁶.

13 “Монгол улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж”, ЖҮХ., 2019

14 “Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийн тоо” (ҮСХ).

15 “GLOBAL COVID-19 Mid-Term Situation Report”, UNICEF., Feb–July 2020, No 9

16 “Монгол. Ковид-19: Нөхцөл байдлын тайлан”, НҮБХАС., 2020 оны 11 сар, No 5

IV. Сэтгэцийн эрүүл мэнд

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн хийсэн **"Ковид-19 цар тахлын үеийн олон нийтийн төсөөлөл, сэтгэл зүй, зан үйл (2020)"** түүвэр судалгаанд оролцогчдын **14 хувь** нь шинэ коронавируст халдвар тархахаас өмнө сэтгэл зүйн тусламж үйлчилгээ авч байсан бол цар тахлаас хойш **21 хувь** нь тус үйлчилгээг авсан байна. Судалгаанд оролцогчдын 66.5 хувь нь өөрийн сэтгэл зүйн байдлаа дэмжих аргуудыг мэднэ гэж хариулсан бол 66.2 хувь буюу 10 хүн тутмын 7 нь өөрийн болон бусдын сэтгэл зүйг дэмжих арга зүйд суралцах шаардлагатай байна гэжээ. Дээрх үзүүлэлтийг хүйсээр харьцуулан үзвэл эмэгтэй оролцогчдын **өөрийн болон бусдын сэтгэл зүйг дэмжих арга зүйд** суралцах шаардлагатай гэж хариулсан нь эрэгтэйчүүдийнхээс илүү өндөр байв.

Хөл хорионы улмаас сургууль, цэцэрлэг хаагдаж, гэр бүлийн гишүүд гэртээ байх болсон тул гэрт харьцангуй их бөөгнөрөл үүссэн. Гэр бүлийн нягтаршлын судалгаанд тайлагнаснаар нэг гэрт хэт олуулаа амьдардаг эмэгтэйчүүд сэтгэл санааны хямралд өртөх нь эрэгтэйчүүдээс илүү өндөр байсан бөгөөд ялангуяа бага насны хүүхэдтэй тохиолдолд сэтгэл санааны гүн хямралд орох эрсдэлийг нэмэгдүүлсэн гэжээ.¹⁷ Дээр нь гэрийн хөлсгүй хөдөлмөрийн ачаалал нэмэгдсэн нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, сэтгэл зүйн дарамтад оруулж байгааг ярилцлагад оролцсон дийлэнх эмэгтэйчүүд илэрхийлсэн байна.

Цар тахлын хөл хорионы дэглэмийг хэрэгжүүлж эхэлснээс хойш **5 өрх тутмын хоёрт** эцэг, эхийн аль нэг нь гэртээ хүүхдээ асрахаас өөр сонголтгүйд хүрч, **3 өрх тутмын нэгд** нь хүүхэд харах зардал өссөн байна. Ийм төрлийн ачаалал нь өрх толгойлсон эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусаж, тэдний дунд гэр бүл болон ажлын ачааллыг тэнцвэржүүлэхээс үүдэлтэй сэтгэл зүйн бухимдал, стресс нэмэгдсэн байна (НҮБХАС, 2020). Дээрх хүчин зүйлс нь нийгмийн амьдралд жендерийн эрх тэгш бус байдал нэмэгдэхэд нөлөөлжээ.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг болон улс төрийн тэгш байдал, тэгш оролцоог хангах нь хөгжлийн зорилго төдийгүй бодит үр дүн юм. Монгол Улс эдийн засгийн хөгжлөө эрчимжүүлье гэвэл эмэгтэйчүүдийн эдийн засаг, нийгэм,

17 Wendy C. Regoeczi. 2008. Crowding in Context: An Examination of the Differential Responses of Men and Women to High-Density Living Environments.

улс төрийн оролцоог нэмэгдүүлэх, тэднийг дэмжих зайлшгүй шаардлагатай байна.

Нэгд, Ковид-19 цар тахал эмэгтэйчүүдийн орлого олох боломж, ажил эрхлэлт, эрүүл мэнд, сэтгэлийн түгшүүр, боловсрол эзэмших боломжид сөргөөр нөлөөлснөөс гадна, хүйсийн тэгш бус байдлаас үүдэлтэй хүчирхийллийг нэмэгдүүлсэн байна. Урт хугацааны туршид хадгалагдан ирсэн хүйсийн тэгш бус байдал, эмэгтэйчүүдийн ажлын байрны хамгаалал муу, цалин доогуур зэргээс шалтгаалан эмэгтэй ажиллах хүчний оролцооны түвшин дунд, бага-дунд орлоготой орнуудад эрчүүдийнхээс бага байгаа нь Монгол Улсын хувьд ч гэсэн адил байна.

Цар тахлын нөлөөгөөр 2021 онд ядуурлын хүйсийн харьцаа **100 эрэгтэй тутамд 118 эмэгтэй** болсон¹⁸ бол 2030 он гэхэд энэ харьцаа **121**-д хүрэхээр байна. Монгол Улсад эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшнийг **65%**¹⁹ хүртэл нэмэгдүүлж, эрэгтэйчүүдийн түвшинд хүргэж чадвал нэг талаас, өрх гэр, бизнес, ажлын байран дахь жендерийн тэгш байдлыг сайжруулна, нөгөө талаас нэг хүнд ногдох ДНБ-ийг **0.5 хувиар** өсгөх боломжтой.²⁰

Хоёрт, Ковид-19 цар тахлын үед жижиг болон бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бизнесийн үйл ажиллагаа, орлого нь цар тахлын өмнөх үеэс эрс муудсан байна. Түүнчлэн, охид, эмэгтэйчүүдийн цалин хөлсгүй ажлын ачаалал, хөдөлмөрийн тэгш бус хуваарилалт нэмэгдэж, эмзэг бүлгийн иргэдийг үл тоох явдал, хүчирхийлэх, эрхийг нь үгүйсгэх хандлага өсжээ. Тиймээс, эмэгтэй бизнес эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэг туслалцаа, тусгайлсан хөтөлбөр нь цар тахалтай холбоотой тэдний стресс, ирээдүйн эрсдэлийг даван туулахад тус дэмтэйгээс гадна, илүү тогтвортой бизнес эрхэлж, гэр бүлээ хамгаалах, нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлж улмаар жендерийн тэгш байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм.

Эдийн засгийн хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд ямар асуудал тулгамдаж байгаа талаар хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгээс **нэгд,** эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, **хоёрт,** санхүүгийн орчныг сайжруулах, **гуравт,** мэдээлэл технологийн шинэчлэлийг дэмжих, **дөрөвт,** хүний нөөц, чадавхыг бэхжүүлэх, **тавд,** бизнесийн орчин буюу олон улсын төсөл

18 НҮБХАС-гийн судалгаа, 2020

19 Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин 52 хувь (YCX., 2021). https://www.1212.mn/mn/statistic/statcate/573055/table-view/DT_NS0_0400_018V1

20 Азийн хөгжлийн банк, 2022. <https://www.adb.org/what-we-do/sectors/dt/knowledge>

хөтөлбөрт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх гэсэн саналууд эрэмбэлэгдсэн²¹ байна.

Гуравт, Эрүүл мэндийн үйлчилгээний хомсдол, тасалдал нь цар тахлын үед охид, эмэгтэйчүүд зэрэг нийгэм, эдийн засгийн хувьд эмзэг иргэдэд илүүтэй нөлөөлж, эрүүл мэндтэй холбоотой тэгш бус байдалд **нийгэм, эдийн засаг, газар зүйн байршил, хүйс, үндэстэн ястны ялгаатай** байдал гол хүчин зүйл болжээ.

Дөрөвт, Олон улсын туршлагаас, жендерийн тэгш бус байдлыг бууруулах хамгийн эхний алхам нь хүйсээр ангилсан бизнес үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэгчдийн **бүртгэл хөтлөх, холбогдох статистик мэдээлэлд** тулгуурлан бодлого, зорилтот хөтөлбөрөө тодорхойлж, хэрэгжүүлэх юм. Энэ нь хүн амын дундах ялгаа, ялгаварлалыг арилгах, жендерийн эрх тэгш байдлыг хангах чухал нөхцөл болдог.

Тухайлбал, улсын нэгдсэн мэдээллийн санд эмэгтэй бизнес эрхлэгч гэж хэнийг тодорхойлох вэ, компанийн гүйцэтгэх захирал нь эмэгтэй байвал эмэгтэй бизнес эрхлэгч үү эсвэл төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь эмэгтэй байвал уу, түүнчлэн эмэгтэй бизнес эрхлэгчийн орлогыг харьцуулах, дүйцүүлэх дээр ямар нэг сулруулсан шалгуур байж болох уу гээд олон асуултууд байна. Эмэгтэй бизнес эрхлэгч банкнаас зээл авах, гадна, дотноос хөрөнгө оруулалт татах зэрэгт жендерийн мэдрэмжтэй ханддаг байх хэрэгтэй байна.

Тавд, Монгол Улс шиг хөгжиж буй орнуудын жендерийн тэгш байдлыг хангахад **төрийн байгууллагуудын авлига, дунд болон доод шатан дах хүнд суртлыг арилгах нь** онцгой ач холбогдолтой.

Эцэст нь, Монгол Улсын Засгийн газраас 2022 онд **“Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”**-г батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ хүрээнд дараах 5 зорилтыг тавин ажиллаж байна. Үүнд: **(1)** Охид, хөвгүүд, эрэгтэй, эмэгтэй хүмүүст эрүүл, аюулгүй амьдрах, сурч боловсрох **тэгш боломж бүрдүүлэх; (2)** Эдийн засгийн хүрээнд жендерийн тэгш боломж, **жендерийн тэгш оролцоог дэмжих; (3)** Жендерийн эрх тэгш байдлыг хангах **тогтолцоог хөгжүүлэх; (4)** Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийг **оролцоо, манлайллыг нэмэгдүүлэх; (5)** Уур амьсгалын **өөрчлөлтүүдийг сааруулах, дасан зохицоход** жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр ажиллаж байна. Жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар

21 МҮХАҮТ, 2022. <https://www.mongolchamber.mn/book/182022>

дундын стратегийн дээрх зорилтыг амжилттай, тууштай хэрэгжүүлж, жендерийн тэгш бус байдлыг бууруулахын төлөө хүчин чармайлт гарган ажиллах нь нэн шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын Үндсэн хууль, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

“Гэр бүлийн хүчирхийлэл: Статистик тойм 2020”, ЦЕГ, ҮСХ, 2021

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага”, MERIT., 2020

“Жендэрийн статистик, суурь судалгааны тайлан” МУЗГ, ЖҮХ., 2020

“Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газар, 2017-2021

“Жижиг, дунд, үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль”, МУ-ын Их Хурал., 2019

“Монгол Улсын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ, 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж”. ЖҮХ., 2019

“Монгол улсад Ковид-19 цар тахлын охид эмэгтэйчүүдийн нийгэм эдийн засгийн амьдралд үзүүлж буй нөлөөллийн судалгаа”, НҮБХХ, АХБ, ЖҮХ., 2020

Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлт, ЭМХТ., 2021

“Монголын жижиг болон бичил бизнес эрхлэгч эмэгтэйчүүд КОВИД-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ”, Азийн сангийн Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх төсөл, Хараат бус Судалгааны хүрээлэн, Канадын ГХЯ., 2021

‘Ковид-19: Нөхцөл байдлын тайлан’, НҮБХАС., 2020 оны 6, 11 сар, No 1, 5.

“Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”. 2020

“Тогтвортой хөгжлийн зорилго 2030” Монгол Улсын Засгийн Газар

Covid-19 Data Repository by the Center for Systems Science and Engineering (CSSE) at John Hopkins University Retrieved from: <https://github.com/CSSEGISandData/COVID-19>

"GLOBAL COVID-19 Mid-Term Situation Report", UNICEF., Feb–July 2020, No 9.

Madgavkar, A., White, O., Krishnan, M., Mahajan, D., & Azcue, X. (2020, July 15). *Covid-19 and gender equality: Countering the regressive effects*. McKinsey & Company. from <https://www.mckinsey.com/featured-insights/future-of-work/covid-19-and-gender-equality-countering-the-regressive-effects>

"Mongolia: Finance Sector Fact Sheet", ADB., 2022

"Mongolia: Public Sector Management Sector Fact Sheet", ADB., 2022

Wendy C. Regoeczi "*Crowding in Context: An Examination of the Differential Responses of Men and Women to High-Density Living Environments*", 2008

Gender Inequality Index 2019. Retrieved from: https://www.undp.org/sites/g/files/zskgke326/files/migration/mn/HDR2020_Mongolia-Summary_English.pdf

Mongolia: Gender-Responsive Sector and Local Development Policies and Actions. Retrieved from: <https://www.adb.org/sites/default/files/project-documents/50093/50093-001-dpta-en.pdf>

"Rapid Assessment Report of the Measures taken due to the Covid-19 pandemic", Ministry of Labor and Social Protection, UNFPA

Assessing the gendered employment impacts of COVID-19 and supporting a gender-responsive recovery., ILO. Retrieved from: https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_emp/documents/publication/wcms_778847.pdf

COVID-19 AND THE PERSPECTIVES FOR GENDER JUSTICE IN MONGOLIA





COVID-19 AND THE PERSPECTIVES FOR GENDER JUSTICE IN MONGOLIA

The views expressed in this publication are not necessarily those of the Friedrich-Ebert-Stiftung.

Author: Davaasuren Sodnomdarjaa Ph.D

Copyright ©2022, by Friedrich-Ebert-Stiftung Mongolia. All rights reserved.

Commercial use of all media published by the Friedrich-Ebert-Stiftung Mongolia (FES Mongolia) is not permitted without the written consent of FES Mongolia.

**COVID-19 AND THE PERSPECTIVES
FOR GENDER JUSTICE IN MONGOLIA**

CONTENTS

BACKGROUND OF THE PAPER.	25
GENDER EQUALITY IN MONGOLIA	26
QUANTITATIVE AND QUALITATIVE STUDY OUTCOMES:	
How has the pandemic impacted gender equality in Mongolia?	29
I. Women and employment	29
II. Domestic violence and women	32
III. Maternal mortality	33
IV. Mental health.	34
CONCLUSIONS AND RECOMMENDATIONS:	
What should be the policy approach?	35
BIOBLOGRAPHY	37

BACKGROUND OF THE PAPER

Gender, race, social class, wealth disparities, and caste systems create inequality among citizens in many countries around the world. Countries around the world continue to make efforts to reduce inequality, but due to the influence of internal and external factors, a tendency for inequalities to increase can be witnessed.

